



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 6/16

Жавхлант

Р.Оюунчимэгийг шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албан ажлын зайлшгүй шаардлагаар Засаг даргын Тамгын газрын дарга Раяагийн Оюунчимэгийг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргаар шилжүүлэн ажиллуулсугай.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга : Э.Хонгорзул Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүд: Э.Уранбайгаль Нягтлан бодогч

Г.Батсайхан Нярав

3. Р.Оюунчимэгийн ажлыг Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн Мөнхчулууны Шаравгаваад хууль журмын дагуу хүлээлцүүлэхийг Комиссын дарга (Э.Хонгорзул)-д холбогдох тооцоог хийж дуусгахыг Нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАТЧУЛУУН